



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 31 өдөр

A/43
Дугаар

Мандалговь

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн

ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтын 1 дэх хэсэгт тусгагдсан “Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засвар” ажлын 494,711,671 (дөрвөн зуун ерэн дөрвөн сая долоон зуун арван нэгэн мянга зургаан зуун далан нэг), “Дэрэн сумын цэцэрлэгийн пасадны засвар”-ын 72,800,000 (далан хоёр сая найман зуун мянга) төгрөгийн төсөл арга хэмжээг тухайн сумдад эрх шилжүүлсүгэй.

2. Эрх шилжүүлсэн ажлыг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлийн үр дүнгээр санхүүжилтийг Эрдэнэдалай сумын Засаг дарга (Б.Лхагвамандал), Дэрэн сумын Засаг дарга (Л.Амартувшин) эрх шилжүүлсэн арга хэмжээний явцын мэдээллийг сар бүрийн 2-ны өдрийн дотор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст тайлagnаж ажиллахыг дээрх сумын Засаг даргын Тамгын газрын дарга нарт даалгасугай

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Энхтайван)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ

4823100291